



Жирэмсний болон амаржсаны тэтгэмж авах эрх:

Тэтгэмжийн даатгалын шимтгэлийг нийтдээ 12 сар ба түүнээс дээш хугацаанд, үүнээс жирэмсний амралт авахын өмнөх сүүлийн 6 сард тасралтгүй төлсөн дараах даатгуулагч эх жирэмсний болон амаржсаны тэтгэмж авах эрхтэй.

- Хүүхдээ 196-аас доошгүй хоног тээж төрүүлсэн;
- Хүүхдээ 196 хоног хүртэл тээгээгүй боловч амьдрах чадвартай хүүхэд төрүүлсэн;
- Хүүхдээ 196-аас доошгүй хоног тээж дутуу төрүүлсэн буюу Эрүүл мэндийн тухай хуулийн 32.1-д заасан үндэслэлээр үр хөндүүлсэн.

Жирэмсний болон амаржсаны тэтгэмжийн хэмжээ, олгох хугацаа:

Даатгуулагч эхэд жирэмсний болон амаржсаны тэтгэмжийг жирэмсний амралт авсан сарын өмнөх шимтгэл төлсөн сүүлийн 12 сарын цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын дунджаас 100 хувиар тооцож 120 хоногийн, ихэр хүүхэд төрүүлсэн бол 140 хоногийн хугацаанд ажлын өдрөөр тооцон тус тус

олгоно.

Жирэмсний болон амаржсаны тэтгэмж бодох хугацаанд нийтээр тэмдэглэх баярын өдөр тохиосон бол уг өдрийг ажлын өдөртэй адилтган тооцож олгох тэтгэмжийг бодно.

Жишээ: Ихэр хүүхэд төрүүлсэн даатгуулагчийн 12 сарын хөдлөмөрийн хөлсний дундаж 2 000 000 төгрөг, тэтгэмжтэй 140 хоног доторх ажлын 98, нийтээр амрах баярын өдөр 3 гэвэл:

Бодолт: а) Сарын дундаж ажлын өдөр: **21 өдөр**

б) Нэг өдөрт ногдох хөдлөмөрийн хөлс, орлого: $2,000,000\text{₮} : 21 \text{ өдөр} = 95,238\text{₮}$

в) Тэтгэмж олгох хоног: $(98 \text{ өдөр} + 3 \text{ өдөр}) = 101 \text{ өдөр}$

г) Олговол зохих тэтгэмж: $95,238\text{₮} * 101 \text{ өдөр} = 9,619,048\text{₮}$

Жирэмсний болон амаржсаны тэтгэмж авах хүсэлт илгээх:

Даатгуулагч Та жирэмсний болон амаржсаны тэтгэмж авах хүсэлтээ portal.ndaatgal.mn цахим хаягаар нийгмийн даатгалын байгууллагад

илгээж болно.